

Ерөнхий мэргэжлийн эмч

Тестийн зөв хариулт-1

1-D, 2-B, 3-E, 4-C, 5-A, 6-B, 7-A, 8-B, 9-A, 10-E, 11-D, 12-C, 13-B, 14-C, 15-B, 16-D, 17-D, 18-E, 19-B, 20-D, 21-B, 22-C, 23-C, 24-C, 25-B, 26-C, 27-B, 28-C, 29-B, 30-E, 31-A, 32-A, 33-A, 34-C, 35-A, 36-A, 37-C, 38-A, 39-A, 40-B, 41-C, 42-B, 43-B, 44-A, 45-E, 46-C, 47-A, 48-A, 49-D, 50-D, 51-D, 52-D, 53-A, 54-D, 55-D, 56-E, 57-C, 58-C, 59-B, 60-C, 61-A, 62-C, 63-D, 64-C, 65-B, 66-D, 67-B, 68-A, 69-A, 70-B, 71-A, 72-B, 73-A, 74-C, 75-A, 76-C, 77-D, 78-B, 79-E, 80-A, 81-D, 82-A, 83-E, 84-A, 85-C, 86-B, 87-B, 88-B, 89-A, 90-C, 91-C, 92-E, 93-C, 94-C, 95-A, 96-E, 97-D, 98-D, 99-D, 100-B,

Тестийн түлхүүр

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

- 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
- 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол (B.)
- 2 ба 4 дүгээр хариултууд зөв бол (C.)
- Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
- Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

- Зөв, Зөв, Зөв (A.)
- Зөв, Зөв, Буруу (B.)
- Зөв, Буруу, Буруу (C.)
- Буруу, Зөв, Буруу (D.)
- Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Гетерополисахаридуудын төлөөлөгчдийг сонгоно уу ?

- A. Цардуул
- B. Мальтоз
- C. Сахароз
- D. Гепарин
- E. Глюкуроны хүчил

/2./ Бамбай булчирхайн гиперфункцийн үеийн эмгэгийг заана уу?

- A. Кретинизм , микседема
- B. Базедовын өвчин, гипертироидизм
- C. Гиперинсулизм, сахарын шижин
- D. Аддисоны өвчин, бронзын өвчин

/3./ Цусанд агуулагдах нийт билирубин ямар хэмжээнээс хэтэрвэл хүний бие шарлах вэ?

- A. 8,5 - 20,5 мкм/л
- B. 0,5 - 4,3 мкм/л
- C. 6,4 -17,1 мкм/л
- D. 17,1 -20,5 мкм/л
- E. 27 -34 мкм/л

/4./ Ямар эмгэгийн үед цэр 3 үе болон тогтдог вэ?

- A. Хурц бронхит
- B. Бронхийн багтраа
- C. Бронхэктази
- D. Уушигны буглаа
- E. Уушигны хатгалгаа

/5./ Судасны ханыг дагаж явдаг, хялгасан судасны ханын сиймхийнүүдийг бөглөж, цус нэвчих, гоожих үзэгдлээс сэргийлдэг эсийг заана уу?

- A. Тромбоцит
- B. Эритроцит
- C. Лейкоцит
- D. Моноцит
- E. Лимфоцит

/6./ HBV-ын репликац явагдаж байгаа халдварын үед ийлдэст илэрдэг маркерийг заана уу

- A. anti HBiAg
- B. HBeAg
- C. anti HCV
- D. anti HIV
- E. anti CMV

/7./ Ямар уураг хүчилтөрөгчийг өөртөө амархан нэгдүүлж авчихаад буцааж алдах нь бага байдаг вэ ?

- A. Миоглобин
- B. Гемоглобин
- C. Метаглобин
- D. Оксигемоглобин
- E. Карбооксигемоглобин

/8./ Өөх тосны гидролизд аль нь заавал оролцдог вэ?

- A. Хүчил
- B. Шүлт
- C. Хүчилтөрөгч
- D. Устөрөгч
- E. Ус

/9./ Милиар сүрьеэ үүсэх үндсэн механизм бол:

- A. Цусаар
- B. Гуурсан хоолойгоор
- C. Лимфээр
- D. Лимф-гуурсан хоолойгоор
- E. Цус-гуурсан хоолойгоор

/10./ Анафилаксийн үед медиаторууд ямар эсээс ялгарах вэ?

- A. Эозинофил
- B. Т-лимфоцит
- C. Цулцангийн макрофаг
- D. В-лимфоцит
- E. Хөөнгө эс

/11./ 10 сарын эхээр танай эмнэлэг дээр томуугийн H1N1 хэв шинжийн халдвар дэгдсэн. Тухайн үед H3N2-ын вакцин хийх боломжтой байна. Эмнэлгийн ажилчид, өвчтөнг хамгаалах зорилгоор ямар арга хэмжээ авах вэ?

A. Эмнэлгийн эмч, ажилчдад шинжилгээ хийж, зөвхөн H1N1-н эсрэг биеийн титр өндөр байгаа хүмүүсийг дэгдэлт намдтал ажиллуулна.

B. Байгаа вакциныг хийнэ

C. H1N1-н халдвар авсан байж болох эмч, эмнэлгийн ажилчдад маск, нүдний шил зүүлгэх арга хэмжээ авна

D. Эмнэлгийн нийт эмч, ажилчдад амантадин \ремантадин\ уулгаж, тохирох вакциныг хийсний дараа 2 долоо хоног үргэлжлүүлэх

E. Эмнэлгийн эмч, нийт ажилчдад 23-валентын пневмококкийн вакцин хийхийг зөвлөнө. Учир нь томуугийн А вирусын халдвартай өвчтөнд хамгийн элбэг тохиолддог халдвар бол S.pneumoniae байдаг

/12./ Гялтангийн шингэнд ямар эс давамгайлах тохиолдолд хурц үрэвслийн тухай бодож болох вэ?

- A. Лимфоцит
- B. Эозинофил
- C. Нейтрофил
- D. Эритроцит
- E. Моноцит

13./ Жирэмсний эрт үед пиелонефритын эмчилгээнд хэрэглэх эм

- A. Нитрофураны бүлэг
- B. Пенициллины бүлэг
- C. цефалоспорины бэлдмэлүүд
- D. Сульфаниламид
- E. Нитроксолины бүлэг

14./ Артерийн гипертензийн хожуу үед шээсэнд гарах өөрчлөлт

- A. Лейкоцитури
- B. Гематури+глюкозури
- C. Протейнури+гематури
- D. Оксалатури
- E. Гипостенури

/15./ Бөөрний ямар өвчний үед Ходсоны шинж илрэх вэ?

- A. Архаг гломерулонефрит
- B. Архаг пиелонефрит
- C. Бөөрний амилоидоз
- D. Бөөрний поликистоз

/16./ Хоёрдогч пиелонефритийн үед доорхи шинжүүдээс нэгээс бусад нь илрэнэ

- A. Дизури
- B. 1мл шээсэнд 100000-аас дээш нян илэрнэ
- C. Бөөрний аяганцар тэвшинцэрийн деформаци
- D. Түүдгэнцэрийн шүүлт буурах
- E. Сувганцаэрын эргэн шимэгдэлт буурах

/17./ Преднизолоны сорилоор юуг илрүүлэх вэ?

- A. Далд гематури
- B. Далд лейкоцитуриг илрүүлэх
- C. Далд протейнуриг илрүүлэх
- D. БШЗ-ын далд үрэвлийг илрүүлэх
- E. Дээрхи бүгд

18./ Хоногийн шээсний хэмжээ 100 мл-ээс багасахыг юу гэж нэрлэх вэ ?

- A. Полиури
- B. Никтири

- C. Поллакури
- D. Дизури
- E. Анури

/19./ Артерийн гипертензийн нефропатийн эрт үед шээсэнд гарах өөрчлөлт

- A. Лейкоцитури
- B. Микроальбуминури
- C. Протейнури+гематури
- D. Оксалатури
- E. Гипостенури

/20./ Өвчтний биеийн байдал муудсан шалтгааныг олохын тулд ямар шинжилгээ хийх вэ?

Хамгийн оновчтой нэгийг сонгоно уу

- A. Бромсульфалеины сорил
- B. Гамма глобулины хэмжээ тодорхойлох
- C. Элэгний эдийн эсрэг биет тодорхойлох
- D. Сийвэнд аммиак үзэх
- E. Альфа фетопротеины хэмжээг тодорхойлох

/21./ Салс нь ямар эсээс ялгарах вэ?

- A. Ханын эс
- B. Нэмэлт эс
- C. Гол эс
- D. Завсрын эс
- E. Дотоод шүүрлийн эс

22./ Элэгний архаг үрэвслийн эмчилгээнд хэрэглэхгүй эмийг сонго.

- A. Амин дэм
- B. Лив 52
- C. Тетрациклин
- D. Эссенциале
- E. Глютамины хүчил

/23./ Олон жилийн турш өвөрмөц бус шархлаат өвчнөөр өвчлөх үед ямар хүндрэл үүсэх вэ.

- A. Бүдүүн гэдэсний хордлогот тэлэлт
- B. Бүдүүн гэдэсний нарийсал
- C. Гэдэснээс цус алдах
- D. Аденокарцинома
- E. Дивертикулез

24./ Хеликобактерийг оношлох амьсгалын сорил нь ямар шинжилгээний аргад багтах вэ?

- A. Биохимийн арга
- B. Иммунологийн арга
- C. Радионуклидын арга
- D. Морфологийн арга
- E. Микробиологийн арга

/25./ Залгих үйл ажиллагаа ямар ямар үе шатаас тогтох вэ?

- A. Зажлагдсан хоолыг залгиур руу түлхэх үе, гүрвэлзэх үе, залгих үе, ходоодны амсар хэсэгт орох үе
- B. Зажлагдсан хоолыг залгиур руу түлхэх үе, залгих үе, ходоодны амсар хэсэгт орох үе

- C. Зажлагдсан хоолыг залгих үе, ходоодны амсар хэсэгт орох үе
- D. Зажлагдсан хоолыг залгиур руу түлхэх үе, ходоодны амсар хэсэгт орох
- E. Зажлагдсан хоолыг залгиур руу түлхэх үе, агших үе, залгих үе, ходоодны амсар хэсэгт орох үе

/26./ Нойр булчирхайн архаг үрэвслийн өвдөлтийн онцлог

- A. Хэвлийн баруун доод хэсэгт хүчтэй хатгуулна, гялтангийн цочролтой
- B. Гурилан зүйл идэхэд цээж хорсож, халуун төөнөж өвдөнө
- C. Хэвлийн дээд хэсэгт, зүүн тал руу бүсэлхийлж ороосон өвдөлттэй
- D. Өөх тостой хоол идсэний дараа баруун сүвээн доогуур хатгуулж өвдөнө
- E. Өвдөлтөөс халширч, хоолны дуршил буурна, турна

/27./ Атеросклерозын ямар үе шатанд фиброзон товруу үүсдэг вэ?

- A. I үе шат
- B. II үе шат
- C. III үе шат
- D. IV үе шат
- E. V үе шат

/28./ Зүрхний хэт авиан шинжилгээний ямар үзүүлэлтээр зүрхний зүүн ховдлын систолын дутагдлыг тодорхойлдог вэ?

- A. Зүүн ховдлын диастолын үеийн хэмжээ
- B. Зүрхний минутын эзлэхүүн
- C. Цацалтын үзүүлэлт
- D. Зүүн ховдлын систолын үеийн хэмжээ
- E. Зүүн ховдлын ханын хөдөлгөөн

/29./ Дараах бэлдмэлүүдээс аль нь артерийн даралт бууруулах, миокардын хүчилтөрөгчийн хэрэгцээг багасгах, зүрхний хэм алдагдал засах үйлчилгээтэй вэ?

- A. Лизиноприл
- B. Атенолол
- C. Изосорбид
- D. Амiodарон
- E. Нифедипин

/30./ Артерийн гипертензийг цус хөдлөл зүйн хэлбэрээр ангилах нь ямар ач холбогдолтой вэ? E

- A. Өвчний явцыг үнэлэх
- B. Ялган оношлох
- C. Тавиланг тодорхойлох
- D. Оношлох
- E. АД бууруулах эмийг зөв сонгох

/31./ Зүрхний дутагдалтай хүмүүс цээж толгойгоо өндөрлөн, хөлөө унжуулсан, албадмал байрлалд ордог. Энэ байрлал нь бага эргэлтийн зогсонгишлыг багасгаж өрцний хөдөлгөөнийг хөнгөвчилдөг тул амьсгаадалт багасдаг.

/32./ Бөөрний эдийн эмгэгийн үед простагландин багасдаг. Простагландин судас тэлж, АД бууруулдаг

/33./ Зүрхний шигдээсийн үед титэм судасны бүлэн үүсдэг. Альтеплаза бүлэн хайлуулдаг.
А

/34./ Гар, хөлийн хурууны үзүүр, чихний омог, хамрын үзүүр, уруул хөхрөхийг акроцианоз гэнэ.Энэ нь зүрхээр өвддөг хүмүүст илэрдэг шинж юм.

/35./ Зүрхний шигдээсийн дараа зүүн ховдолд бүлэн үүсдэг. Энэхүү тохиолдолд варфарин хэрэглэдэг.

/36./ Цэвэршилтийн өмнөх насны эмэгтэйчүүд нь зүрх судасны өвчнөөр өвдөх магадлал бага байдаг. Энэ нь холестериньг багасгадаг эстроген дааврын үйлчлэлтэй холбоотой

37./ Хоёр хавтаст хавхлагын гажигтай хүнийг харж ажиглахад “Faciesmitralis” илэрдэг. Энэ нь нарийссан нүхээр цус шахагдахдаа хуйларч орсноос болдог.

38./ Зүрхний шигдээсийн үед титэм судасны бүлэн үүсдэг. Стрептокиназа бүлэн хайлуулдаг.

/39./ Зүрхний зүүн ховдлын трансмураль шигдээсийн үед цүлхэн үүсдэг. Цүлхэн нь зүрхний архаг дутагдал үүсэхэд нөлөөлдөг

/40./ 30настай эмэгтэйд субтотал тиройдэктоми хийснээс 12 цагийн дараа өвчтөн цочролын байдалд орж амьсгал нь боогдсон. Үзэхэд тахикарди илэрсэн, хүзүүний урд хэсэгт овойсон, хагалгааны шархны боолт хуурай байв. Энэ тохиолдолд яаралтай ямар арга хэмжээ авах вэ?

- А. Амаар нь цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавих
- В. Хагалгааны шархыг нээх
- С. Цусан дахь кальцийг тодорхойлох
- Д. Морфинтарих
- Е. Хүчилтөрөгчөөр амьсгалуулах

/41./ Посттромбофлебитийн хам шинжийн үед хөлийн аль хэсэгт шархлаа үүсэх вэ?

- А. Гуянд
- В. Шилбэний гадна дунд хэсэгт
- С. Хөлийн тавхайд
- Д. Шилбэний дотор, доод гуравны нэгд
- Е. Шилбэний гадна доод 1/3 – д

/42./ Шамбарамын үед мэс засал хийсний дараа аль хүндрэл нь зонхилон тохиолдох вэ?

- А. Хошногоны амсар нарийсах
- В. Шулуун гэдэс унжих
- С. Шулуун гэдэсний орчмын цоорхой
- Д. Уушигны артерийн бөглөрөл
- Е. Хүндээр бие засахад хөндүүр болох

/43./ Гэнэт өвдөлтийн дараагаар шарласан, элэг бага зэрэг томорсон, цэсний хүүдий үл мэдрэгдэнэ, шээс хар хүрэн өнгөтэй, баас цайвар, билирубин бага нэмэгдсэн тохиолдолд ямар төрлийн шарлалтанд тохирох вэ?

- A. Цуллагын
- B. Бөглөрөлтийн
- C. Цусны
- D. Цус сэлбэсний
- E. Хавсарсан

/44./ 12 хуруу гэдэсний шархлааны хамгийн элбэг тохиолдох шинж тэмдгийг заана уу?

A. Өлөн үед өвдөлт өгнө. Хоол идсэний дараагаар аюулхай ба баруун сүврэгсэд дор өвдөлт арилна

- B. Аюулхай орчимд хорсоно
- C. Идсэн хоол хүнсээрээ бөөлжинө
- D. Хошногноос ягаан цус гарна
- E. Баруун сүврэгсэдийн дор байнга өвдөнө

/45./ Өвчтөний биеийн жин буурна, амархан ядарна, бага зэрэг халуурна, судасны цохилт ихсэнэ, сэтгэл хөдлөлийн тогтворгүйтэл, гэдэс өвдөнө, баас нь олширно. Хамгийн магадлалтай оношийг заана уу.

- A. Ходоодны хортхавдар
- B. Золлингер-Эплисоны хам шинж
- C. Нойр булчирхайнаас болж чацга алдах
- D. Целиакит
- E. Тиреотоксикоз

/46./ Гэдэсний түгжрэлийг онцлох шинжилгээний илүү мэдээлэл бүхий арга нь аль вэ?

- A. Хэвлийн хөндийн тойм рентген зураг авалт ба харалт
- B. Бүдүүн гэдэс дурандах
- C. Тодотгогч бодисын тусламжтай гэдэсний замыг шинжлэх
- D. Ходоод дурандах
- E. Судсаар тодотгогч бодистой шинжлэх

/47./ Мэс заслын үед цэсний ерөнхий сувгийн доторх саатлыг үнэлж дүгнэх хамгийн оновчтой аргыг сонгоно уу.

- A. Цэсний сувгийн зураг авах
- B. Цэсний сувгийн даралт хэмжих
- C. Цэсний ерөнхий сувгийг дурандах
- D. Мэс ажилбарын үед хэт авиагаар шинжлэх
- E. Сувгуудыг сэтгүүрдэх

/48./ . Цэсний ерөнхий цоргоны зонхилон залгаас хийдэг хэсэг нь:

- A. Супрадуоденал
- B. Элэгний
- C. Нойр булчирхайн

- D. 12 хуруу гэдэсний
- E. Ходоодны

/49./ Гуяны гүн хураагуур судасны тромбозын үед хэрэглэх хамгийн зохимжтой эмчилгээ аль нь вэ?

- A. Гепарин
- B. Хөндий венд шүүлтүүр суулгах
- C. Стрептокиназа
- D. Венийн тромбыг авах
- E. Антибиотикийн эмчилгээ

/50./ 42 настай өвчтөнд "тиреотоксикозын хүнд хэлбэр" гэдэг онош тавигджээ. Эмчилгээний оновчтой тактикийг заана уу.

- A. Яаралтай мэс засал хийх
- B. Эмийн хавсарсан эмчилгээ
- C. Эмээр эмчлэх, оршин суугаа газраар нь булчирхайн эмч хяналтандаа авах
- D. Эмээр эмчлэн, бамбай булчирхайг авах
- E. Эмээр эмчлэн, бамбай булчирхайг тайрах

/51./ Хүндээр бие засах үед хошногт маш хүчтэй өвдөлт илрэх нь аль эмгэгийн байх вэ?

- A. Цочмог шамбарам
- B. Шамбарамын судасны бөглөрөл
- C. Шамбарамын зангилаа хавчигдах ба унжих
- D. Шулуун гэдэсний амсрын салст язрах
- E. Цочмог парапроктит

/52./ Фолийн хүчлийн үйлдлийн механизмыг сонгоно уу?

- A. 5 метилтетрагидрофолатаас Тетрагидрофолат үүсгэж эсийн нуклейн хүчлийн нийлэгжилтэнд нөлөөлнө
- B. Гемийн бүтцэд орж гемоглобины нийлэгжилтийг дэмжинэ
- C. Улаан эсийн JAK2 ферментийг идэвхжүүлж эсийн хуваагдлыг дэмжинэ
- D. Тимидилат синтеза ферментийн бүрэлдэхүүнд орж эсийн нуклейн хүчлийн нийлэгжилтэнд оролцоно
- E. Прогениторыг идэвхжүүлж цагаан эсийн дүрст элементийн хөгжлийг хангана

/53./ Төмөр дутагдлын цус багадалтын үеийг сонгоно уу?

- A. Төмөр дутагдлын цус багадалтын үеийн эмнэлзүй, лабораторын шинж илрэх үе
- B. Сийвэнгийн Fe багасаж, гемоглобин хэвийн байх
- C. Сийвэнгийн ферритин багасаж, Fe, гемоглобин хэвийн байх
- D. Сийвэнгийн ферритин багасаж, төмөр ихсэх
- E. Сийвэнгийн төмөр ихсэж, ферритин ихсэх

/54./ Феррум лекийн төмрийн агууламжийг сонгоно уу?

- A. 10мг
- B. 162мг

- C. 150мг
- D. 100мг
- E. 50мг

/55./ Хүүхдийн яаралтай тусламжийн үед эмнэлзүйн ямар тохиолдолд аврах амьсгалуулалтыг хийх вэ?

- A. Ухаантай, амьсгалын дутагдалтай
- B. Ухаангүй
- C. Ухаангүй, амьсгалын дутагдалтай
- D. Ухаангүй, амьсгал зогссон, судасны лугшилт тэмтрэгдэнэ
- E. Ухаангүй, амьсгал зогссон, судасны лугшилт тэмтрэгдэхгүй

/56./ Амьсгалын дутагдлын эмнэлзүйн шинжүүдийг нэрлэнэ үү?

- A. Амьсгалын агаарын урсгалын чимээ шуугиж, хяхнаж сонсогдох
- B. Айж бачимдах, хамрын угалз сарталзах, ам ангайх
- C. Царай хөхөлбөр, баргар, хөлөрсөн
- D. Амьсгал давчидсан, олширсон
- E. Дээрх бигд

/57./ 58 настай эрэгтэйн түрүү булчирхайн хавдар нь 5 сарын өмнө оношлогдож, хагалгаа хийлгэсэн боловч нурууны L4-L5 түвшинд үсэрхийлэл өгсөн ба нугас дарагдаж эхэлсэн тул 4 сарын өмнөөс нуруулуу үе үе хатгуулж, хутгалах мэт өвдөх болсон. Нуруу нь байнга чилж өвдөх боловч үе үе хатгуулж өвдөхөд дуу алдах, нойр алдах, хөмсгөө зангидаж ёолох болсон. Өвчтөн Трамадол ууж өвдөлтөө намдаадаг байсан боловч сүүлийн хоногуудад өвдөлт намдахаа больсон. Энэ өвчтөний өвдөлтийг Wong Baker-ийн ангиллаар ангилах.

- A. Носисептив
- B. Невропатик
- C. 7-10 -р зэрэг
- D. 4-6 –р зэрэг
- E. 1-3 –р зэрэг

58./ Морфиныг 4 цагаар 10 мг-р булчинд тарьж байсан бол уудаг IRMS морфинд шилжихдээ хэдээр уулгах ёстой вэ?

- A. 4 цагаар 10 мг-р уулгах
- B. 12 цагаар 30 мг-р уулгах
- C. 4 цагаар 30 мг-р уулгах
- D. 4 цагаар 15 мг-р уулгах
- E. 12 цагаар 15 мг-р уулгах.

59./ Өвчтөн А 64 настай, элэгний хорт хавдартай ба хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд сул шингэн тогтоогдсон тул Спиринолактон 3 сарын турш 100 мг-аар ууж, 2 сарын турш 200 мг-аар буюу 8 шахмалаар өглөө бүр уудаг болсон. Түүний асцит нэг хэсэг буурсан байснаа одоо дахин ихсэж эхлэв. Одоо ямар арга хэмжээ авах вэ?

- A. Спиринолактоныг 200- 300 мг-аар өглөө бүр уулгах
- B. 200 мг Спиринолактоныг 40 мг Фуросемидтэй хавсарч уулгах.
- C. Фуросемид дангаар нь 40 мг-аар уулгах
- D. Фуросемид дангаар нь 80 мг-аар уулгах

Е. Парацентез хийх

/60./ Уушгины судсанд эмболи үүссэн өвчтөн амьсгаадаж, бачуурч байвал шалтгааны эсрэг ямар эмчилгээ хийх вэ?

- A. Антибиотик
- B. Хими эмчилгээ
- C. Тромболитик буюу тромб хайлуулах эмчилгээ
- D. Гуурсан хоолой тэлэх эмчилгээ
- E. Кардиотоник буюу дигоксин эмчилгээ

/61./ Баруун гар огт хөдлөхгүй, тонус, гүний рефлексүүд арилсан. Мэдрэхүй хэвийн.

- A. сул саа
- B. чангарсан саа
- C. талсаа
- D. тэнцвэргүйдэл
- E. анестези

/62./ Аль нь цусны даралт ихсэлтийн ретинопатийн үед илэрдэггүй шинж вэ?

- A. Ангиопати
- B. Ангиосклероз
- C. Ангioneкроз
- D. Ретинопати
- E. Нейроретинопати

/63./ Шар толбо харааны мэдрүүлийн зээрэнцгийн хооронд венийн судас гүрийж махирлах шинжийг

- A. Салюс Гунн – 1 шинж
- B. Салюс Гунн – 2 шинж
- C. Салюс Гунн – 3 шинж
- D. Гвистын шинж
- E. Голдманн шинж

/64./ Хоёр нүдний хугалах хүч адилгүй байхыг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Гиперметропи
- B. Миопи
- C. Анизометропи
- D. Астигматизм
- E. Эмметропи

/65./ Зүүн ховдлын нум хаана байрладаг вэ?

- A. Linea medioclavicularis sinistra -аас дотогш 1,5-2,0 см зайд
- B. Linea medioclavicularis dexter-аас дотогш 1,5-2,0 см зайд
- C. Linea medioclavicularis-аас гадагш 2,0-2,5 см зайд
- D. Linea parasternalis sinistra-аас дотогш 1,5-2,0 см зайд
- E. Linea mammilaris sinistra -аас дотогш 2,0-2.5 см зайд

/66./ Хавдарын олон улсын TNM ангилалын дагуу уушгины хавдар T2 ангилалд ямар хэмжээтэй байх вэ?

- A. 2 см >
- B. 2 см <
- C. 3 см <
- D. 3 см >
- E. Хэмжээ хамаарахгүй

/67./ Зүрхний хөндлөн хэмжээ гэж юу вэ?

- A. Баруун талын судас тосгуурын өнцгийг зүүн талын зүрх өрцний өнцөгтэй холбосон шулуун шугам
- B. Зүрх судасны сүүдрийн хамгийн захын 2 нумаас тэгш татсан шугамуудын урт
- C. Зүүн ховдлын нумын эхнээс зүүн зүрх өрцний өнцөгт татсан шулуун шугам
- D. Баруун ба зүүн талын зүрх өрцний өнцгийг холбосон шугам

/68./ 233. Хар тугалганы, нүүрсхүчлийн хийн ба атропины хордлогын үед үе үе кетонури илэрнэ УЧИР НЬ дээрх хордлогуудын үед өөх тос, нүүрс-усны солилцоо алдагдсантай холбоотой кетонури илэрнэ

69./ Цочмог хэлбэрийн гепатитын үед сийвэнгийн Асат ба Алатын идэвхийн харьцаа буюу ДеРитисийн коэффициент ямагт нэгээс бага байдаг. УЧИР НЬ энэ үзүүлэлтээр элэгний гаралтай ферментемийг зүрхнийхээс ялган оношлох боломжтой.

/70./ Зүрхний булчингийн шигдээс өвчний үед ЛДГ-ын идэвхи ихсэх нь оношийн ач холбогдолтой. УЧИР НЬ 36-48 цагийн дараа дээд цэгтээ хүртэл ихэсч хэвийн түвшингээсээ 10-15 дахин нэмэгддэг.

/71./ Гипергликеми нь дотоод шүүрлийн эмгэгтэй холбоотой. УЧИР НЬ цусны сахарын хэмжээ эрс ихсэх нь нойр булчирхайн инсулины шүүрэл дутагдалтай болсноос үүсэх чихрийн шижингийн үед гарна.

/72./ Эсийн дотор глюкоз хүчилтөрөгчтэй, хүчилтөрөгчгүй замаар исэлдэн задарч энерги ялгаруулдаг. УЧИР НЬ нэмэгдэл пентозфосфатын зам хэрэглэдэггүй

/73./ Хамрын хөндийн дээд хана буюу дээврийг юу бүрдүүлэх вэ?

- A. Хамрын хос яс, шүүр ялтас, гавлын өмнөд хотгор, суурийн хөндийн өмнөд хана
- B. Хамрын хос яс, шүүр ялтас, таславч
- C. Хамрын хос яс, шүүр ялтас, таславч, тагнай явны хэвтээ ялтас
- D. Зажуур яс
- E. Үнэрлэхүйн мэдрэл

/74./ Улаан хоолойн урт хэд вэ?

- A. 18-20см
- B. 20-22см
- C. ≈25 см
- D. ≈35 см
- E. ≈45 см

/75./ Умайн хүзүүний хавдрын хэдэн хувь нь HPV вирусээр үүсгэгддэг вэ?

- A. 95%
- B. 80%
- C. 50%
- D. 25%

/76./ Миеломын өвчин хаана хамгийн элбэг тохиолддог вэ?

- A. Дунд чөмөгний ба шилбэний яс
- B. Ясны диафиз
- C. Чөмөгт жижиг яснууд
- D. Гавлын хавтгай яснууд
- E. Өвдөгний үений яснууд

/77./ 76 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Тэр шатаар явах үед амьсгааддаг байсан бол одоо тайван байх үедээ ч амьсгааддаг болсон. Тэр өглөө сэрэхэд хавангүй хэрнээ, орой болоход хоёр шилбэ, шагайгаар хавагнасан байдаг. Шөнө босч шээдэг болсон гэж өгүүлсэн байв.

Түүний хаван ямар шалтгаантай үүссэн байх магадлал өндөртэй вэ?

- A. Бөөрний өвчний шалтгаантай хаван
- B. Зүрхний дутагдлын шалтгаантай хаван
- C. Тунгалгын хаван
- D. Элэгний дутагдлын ба үүдэн венийн даралт ихссэнтэй холбоотой хаван
- E. Уураг дутагдлын хаван

/78./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөгрүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь төрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьеэгийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар өвчин байх магадлал илүү өндөр байна вэ?

- A. Хэрх өвчин
- B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
- C. Остеоартрит
- D. Тулай
- E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр

/79./ Урт хугацаагаар илрэх сэтгэл хөдлөлийг дурьдана уу?

- A. Мэдрэх сэтгэл Эмоци
- B. Дотоод сэтгэлийн мэдрэмж /чувство/
- C. Хүсэл шунал /страсть/
- D. Сэтгэл цочирдол /аффект/
- E. Зан сэтгэл /настроение/

/80./ Амьдралын стрессээс шалтгаалах нойргүйдэл хэдий хугацаагаар үргэлжлээд хэвийн байдалдаа ордог вэ?

- A. Нэг долоо хоногоос түүнээс бага
- B. Хоёр долоо хоног
- C. Гурван долоо хоног
- D. Дөрвөн долоо хоног
- E. Таван долоо хоног

/81./ Хүүхдийн насны криз хэд байдаг вэ?

- A. Насны 1 криз байдаг
- B. Насны 8 криз байдаг
- C. Насны 5 криз байдаг
- D. Насны 4 криз байдаг
- E. Насны 2 криз байдаг

/82./ Хоол хүнсний хамт гаднаас авсан нүүрсус боловсорч задраад голдуу глюкоз болдог. ЯАГААД гэвэл бусад моносахарууд ч глюкозад шилжээд шимэгдэх тул цус болон бүхий л биологийн шингэнүүдэд нүүрс ус нь голдуу глюкоз байдлаар оршдог.

/83./ Чихрийн шижин өвчний үед сахарын ачаалалт сорилд өөрчлөлт гардаггүй. УЧИР НЬ өлөн үеийн сахарын түвшин хэвийн, шээсэнд нь глюкоз илэрдэггүй.

/84./ Нарийн гэдэсний ханаар моносахарууд шимэгдэж цусанд ордог. УЧИР НЬ хоол хүнсээр авсан полисахар, олигосахар, дисахарууд ходоод гэдэсний замд моносахар болтлоо задарч боловсордог

/85./ Халдварт гепатитын шарлалтын үеийн эхний 7 хоногийн турш ЛДГ-н идэвх их байдаг. УЧИР НЬ өвчин хөнгөн буюу дунд зэргийн явцтай бол ферментийн идэвх хэвэндээ харин хоёрдогч байдлаар хорт хавдар үсэрхийлсэн үед ЛДГ-н идэвх хэвийн буюу 50% буурдаг байна.

/86./ Хавчуур тавих нөхцөл бүрдсэн тохиолдлыг заана уу?

- A. Ураг амьд, шингэний бүрхүүлгүй, умайн амсар 6,0см нээлттэй, ургийн толгой баруун ташуу
- B. Ураг амьд, шингэний бүрхүүлгүй, умайн амсар бүрэн нээгдсэн, аарцгийн хэмжээ хэвийн, ургийн толгой аарцгийн өргөн хэсгийн хавтгайд их сегментээр тавигдсан
- C. Ураг амьд, умайн амсар бүрэн нээгдсэн, шингэний бүрхүүл хагараагүй, эхийн аарцаг хэвийн, ургийн толгой гарах хэсгийн шулуун хэмжээтэй давхацсан
- D. Ургийн зүрхний цохилт сонсогдохгүй, умайн амсар бүрэн нээгдсэн, шингэний бүрхүүлгүй, эхийн аарцаг хэвийн, суман заадас гарах хэсгийн шулуун хэмжээтэй давхацсан
- E. Нөхцөл шаардлагагүй

/87./ Сарын тэмдэгийн мөчлөгийн хугацааг яаж тогтоох вэ?

- A. БЮМ ирээд дууссан өдрөөс дараагийн сарын тэмдэгийн анхны өдөр хүртэл
- B. БЮМ ирсэн анхны өдрөөс дараагийн сарын тэмдгийн анхны өдөр хүртэл
- C. БЮМ дууссан өдрөөс дараагийн сарын тэмдэг дууссан өдрийг хүртэл
- D. Сарын эхний 5 хоног
- E. Сарын сүүлийн 5 хоног

/88./ Ямар үед зүрхний өвчтэй эмэгтэйд гликозид хэрэглэх вэ?

- A. I хоромд зүрхний агшилт 70, амьсгал 18 удаа байхад
- B. I хоромд зүрхний агшилт 115, амьсгал 24-өөс дээш болвол
- C. Зүрхний агшилт 88, амьсгал 20 болбол
- D. Зүрхний агшилт 70, амьсгал 30 болбол
- E. Зүрхний агшилт 80, амьсгал 18 болбол

/89./ Кольпоцитологийн шинжилгээг дараах оношилгоонд хэрэглэнэ:

- A. Жирэмсэн үеийн эстроген дааврын ханалтыг дам аргаар тодорхойлох
- B. Үтрээний цэвэршилтийн зэргийг тогтоох
- C. Умайн хүзүүнээс бактери илрүүлэх
- D. Ургийн гаж хөгжлийг илрүүлэх
- E. Ургийн шингэн гарсан эсэхийг тодорхойлох

/90./ Пролактин даавар хаана боловсорч ялгарах вэ?

- A. Өндгөвчинд
- B. Умайд
- C. Өнчин тархинд
- D. Хөхний булчирхай
- E. Харааны товгор

/91./ Умайн гадуурх жирэмсний үед хамгийн эрт илрэх шинж тэмдэг

- A. Цус багадалт шинжүүд
- B. Бөөлжилт илрэх
- C. Сарын тэмдэг хоригдох
- D. Сарын тэмдэг хоригдоогүй
- E. Артерийн даралт багасах

/92./ Төрсний дараах үеийн үргэлжлэх хугацаа

- A. 7 хоног
- B. 2 долоо хоног
- C. 4 долоо хоног
- D. 5 долоо хоног
- E. 6 долоо хоног

/93./ Амниоскопи хийх эсрэг заалт:

- A. Дутуу төрөхийг завдах
- B. Илүү тээлт
- C. Ихэс түрүүлэлт
- D. Төрөлтийн үйл эхлэх үед
- E. Ургийн шингэн гарахад

/94./ Цусны үндсэн уургийг юу гэж нэрлэдэг вэ ?

- A. Миоглобин
- B. Метагемоглобин

- C. Гемоглобин
- D. Оксигемоглобин
- E. Карбогемоглобин

\95./ Давсагны үрэвслийн үед ямар хучуур эс давамгай ялгарах вэ?

- A. Дугуй
- B. Хавтгай
- C. Гонзгой
- D. Бөөрний
- E. Сүүлтэй

/96./ Цусанд уургийн хэмжээ ихсэх үзэгдлийг юу гэх вэ?

- A. Гиперпротейнемия
- B. Гипопротейнемия
- C. Дефектопротейнемия
- D. Парапротонеймия
- E. Аропротейнемия

/97./ Лимфоцит, нейтрофилтэй хамтран молекулын түвшинд нарийн хоршсон үйл ажиллагаа явуулж бие махбодыг эмгэгээс хамгаалах, онгон дархан байлгах хамгаалалтын хүчирхэг системийг бүрдүүлдэг эсийг заана уу?

- A. Тасархай бөөмт нейтрофил
- B. Эозинофил
- C. Базофил
- D. Моноцит
- E. Лимфоцит

/98./ Трансферрин уураг юуг тээвэрлэх вэ?

- A. Хүчилтөрөгчийг
- B. Нүүрсхүчлийн хийг
- C. Өөхтос, нүүрс усыг
- D. Төмрийг
- E. Витамин ба гормоныг

/99./ Ямар өвчний үед ЭТХ (эритроцетын тунгаах хурд) маш их өндөрсдөг вэ? /80-90 мм/цаг хүртэл

- A. Уушигны хатгалгаа
- B. Хурц бронхит
- C. Ревматизм
- D. Миеломын өвчин
- E. Цус багадалт

/100./ Хоргүйжүүлэх, гистамины бүтээгдэхүүнийг шимэгдүүлэх үүрэгтэй бөгөөд харшлын эсрэг үйлчилдэг эсийг заана уу?

- A. Тасархай бөөмт нейтрофил
- B. Эозинофил
- C. Базофил
- D. Моноцит
- E. Лимфоцит